



Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа

Мэдээний тойм:

- Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа
- Үнэт цаасны арилжааны мэдээ
- “Аргай бест”ХХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг сэргээлээ
- Тулга, Монголэмимпекс компаниудын үнэт цаасыг МХБ-ийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа
- Ногдол ашиг хуваарилах аар шийдвэрлэсэн хувьцаат компаниуд
- МХБ-ийн вэб сайт шинэчлэгдлээ
- Үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалт 6 дугаар сарын 17 -нд эхэлнэ

Монгол Улсын бий болгон бүрэн шинэчилж, орчин үеийн санхүүгийн зах нийгэм, эдийн засгийн төлбөр тооцооны Т+3 горимыг зээлийн өрсөлдөөнт орчныг бий хурдацтай хөгжил, нэвтрүүлсэн зэрэг олон ажлыг болгох, бүтээн байгуулалтын түүнд гарч буй хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн, зах төслүүдийг санхүүжүүлэх өөрчлөлтүүд болон зээлд мөрдөгдөж буй дүрэм цаашлаад дотоод, гадаадын энэхүү хөгжлийг урт журмуудыг шинэчлэн баталж үйл хөрөнгийн бирж дээр үнэт цаасыг хугацаанд тогтвортой ажиллагаандаа мөрдөж эхэлсэн. давхар бүртгэх ажлыг зохион хадгалах, цаашид тэлэх Гэвч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгуулах чиглэлээр УИХ, Засгийн зорилтыг хангахад үндэсний байсан “Үнэт цаасны зах зээлийн газрын зүгээс бодлогын түвшинд хөрөнгийн зах зээл, түүний тухай хууль” нь олон улсын хэлэлцэж ирсэн нь ийнхүү биеллээ дэд бүтцийг олон улсын жишгийн дагуу ажиллахад олох боломж бүрдээд байна. Үнэт түвшинд хүргэх нэн шаардлагатай зохицуулалтууд цаасны зах зээлийн тухай хуулийн тэргүүний шаардлага тусгагдаагүй, шинэчлэлийг бүрэн шинэчилсэн найруулгаар зах зээлд тулгараад байсан билээ. хэрэгжүүлэх боломжийг бий болж буй боломжуудаас дурьдвал:

Үүний дагуу Төрийн өмчийн хороо, Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн биржтэй стратеги хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ” байгуулж, хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлын хүрээнд олон улсын жишигт хүрсэн зах зээлийн дэд бүтцийг

Хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлыг үр дүнтэй болгох, дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалтыг татах,

\* Гадаадын томоохон бирж дээр үнэт цаас гаргасан Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд дотоодын зах зээл дээр үнэт цаасаа гаргах “давхар бүртгэл”-ийн зохицуулалт орсон нь дотоодын зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, олон нийт тэдгээр компаниудын үнэт цаасыг эзэмшиж түүнээс ашиг хүртэх боломж нээгдэнэ. Түүнчлэн, олон

Үнэт цаасны арилжааны мэдээ

Хувьцааны арилжаа: 5 дугаар сарын 1-нээс 31-ний хооронд:

Арилжаа явагдсан өдөр	23
Арилжигдсан ширхэг	1.7 сая
Арилжигдсан дүн	1,041.1 сая.төг
Арилжигдсан компанийн тоо	92
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	1566
Өдрийн дундаж	45.3 сая.төг

Хамгийн их өсөлттэй:	Хотдевелопмент /SDT/	+74.85%
	Бэрх уул /BEU/	+66.01%
	Шивээ Овоо /SHV/	+64.41%
бууралттай:	Монгол алт /ERS/	-49.92%
	Зоос гоёл /ZOO/	-20.42%
	Монголын цахилгаан холбоо /MCH/	-17.99%

Зах зээлийн үнэлгээ: 1,373.8 тэрбум.төг  
922.2 сая ам.доллар

TOP-20 индексийн өөрчлөлт: 13,835.84 / +1.06%

TOP-20 индексийн үзүүлэлт



2013 оны 5 дугаар сарын 1-нээс 31-ний хооронд нийт 23 удаагийн арилжаа явагдаж, 92 компанийн 1,041.1 сая төгрөгийн үнийн дүн бүхий 1.7 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Таван толгой” ХК /243.7 сая.төг/, “АПУ” ХК /135.7 сая.төг/ “Дорнод худалдаа” ХК /97.7 сая.төг/ байсан байна.



2013 оны 6 сарын 3  
(15, 16-р хэвлэл)

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

улсын биржүүдтэй давхар бүртгэлийн асуудлыг нарийвчлан зохицуулсан нь дотоодын компаниуд олон улсын зах зээлд хувьцаа, хадгаламжийн бичгийг гаргах боломжийг нээж байгаа юм.

\* Суурь үнэт цаасыг үндэслэн хадгаламжийн бичиг болон бусад төрлийн үүсмэл үнэт цаас гаргахтай холбогдсон харилцааг нарийвчлан тодорхойлсон нь зах зээл дээр арилжигдаж буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдад олон төрлийн сонголтыг санал болгох боломжийг олгохын сацуу зах зээлийг тэлэх, улмаар олон улсын жишгийн дагуу ажиллахад ойртуулна. Суурь үнэт цаасыг хадгалах үнэт цаасны хадгаламж /кастодиан/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын талаар заалтууд орсон нь кастодианы үйл ажиллагааг нэвтрүүлэх боломжийг мөн нээж байна.

\* Олон улсын жишгийн дагуу үнэт цаасны номиналь эзэмшигч болон бенефициар өмчлөгчийн тухай нарийвчилсан заалт оруулсан. “Номиналь эзэмшигч” гэж үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд хадгалагчаар бүртгэгдсэн, тухайн үнэт цаасны өмчлөгч /бенефициар өмчлөгч/ бус зохицуулалттай этгээдийг хэлдэг бол “бенефициар өмчлөгч” гэж хуульд заасны дагуу номиналь эзэмшигчийн нэр дээр өөрийн өмчлөл дэх үнэт цаасыг бүртгүүлсэн, тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрхтэй жинхэнэ өмчлөгчийг хэлнэ. Ийнхүү, номиналь болон бенефициар өмчлөлийг тусгасан нь гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчид зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлж байгаа юм.

\* Компаниуд хувьцаагаа олон нийтэд нээлттэй болон хаалттай хүрээнд гаргах тогтолцоог олон улсын жишигт хүргэж уян хатан, богино хугацаанд шийдвэрлэх, бүртгэлтэй хувьцаат компаниудын үүргийг нарийвчлан зохицуулсан бөгөөд үйл ажиллагааны тунгалаг зарчимд шилжих, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зохицуулалтууд орсон.

\* Үнэт цаасны төлбөр тооцооны дараа төлбөрт горимд шилжиж байгаатай холбогдуулан түүний нарийвчилсан зохицуулалтыг нэвтрүүлсэн. Зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн ажиллагааны хүрээнд үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны урьдчилсан системийг олон улсын жишгийн дагуу дараа төлбөрт системд шилжүүлэх ажил 2012 онд хийгдсэн. Төлбөр тооцооны дараа төлбөрт систем гэдэг нь арилжаанд оролцогчид үнэт цаас худалдан авсан өдрөөс хойш арилжааны төлбөр тооцоог тодорхой хугацаанд багтаан хийх боломж олгож, үнэт цаас эзэмших эрхийг төлбөр бүрэн төлөгдсөний дараа шилжүүлэх үндсэн зарчим бүхий дараа төлбөрт систем юм. Энэхүү горим нь гадаад, дотоодын хөрөнгийн урсгалыг татах таатай нөхцөл бүрдүүлэх, үнэт цаас худалдан авах ажиллагааны хүндрэл, чирэгдлийг арилгах, үргүй зардлыг багасгах зэрэг олон давуу талтай.

\* Манай улсын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа нь үндэстэн дамнасан шинжтэй болж байгаагийн хирээр уг зах зээлийн зохицуулагч байгууллага гадаад улсын ижил төрлийн зохицуулагч байгууллага болон үнэт цаасны хорооны олон улсын байгууллага /IOSCO/-тай мэдээлэл солилцох, тодорхой мэдээллээр хангах зэргээр хамтран ажиллах зохицуулалтууд орж буй юм. Түүнчлэн, олон улсын стандартад нийцүүлэн гаргасан энэхүү хууль нь манай хууль эрх зүйн орчинг олон улсад хүлээн зөвшөөрөх томоохон алхам болсон юм. Өмнө нь дотоодын компаниуд гадаад зах зээл дээр бүртгэгдэхэд манай хууль эрх зүйн орчин олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан тул тэдгээр компаниуд гадаадад хуулийн этгээд байгуулах замаар олон улсын зах зээлд гарч байсан бол өнөөдрийн энэхүү хуулиар тэр боломж нээгдэж байгааг дуулгахад таатай байна.

\* Үнэт цаасыг санал болгоход тавигдах шаардлага, үнэт цаасны танилцуулгад тусгах мэдээлэл, түүнээс үүдэх эрсдэлийг бууруулах мөн хариуцлагын тогтолцоог сайжруулах

талаар заалтууд орсон. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн хөгжил болон зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийн чанарыг сайжруулах, мэдээллийг нээлттэй, тэгш хүртээмжтэй түгээх түүнтэй холбоотой оролцогч талууд болон эрх бүхий этгээдийн мэдээлэх үүрэг, хариуцлагыг хуульчилж өгснөөр олон нийтийг үнэн, зөв бодит мэдээллээр хангах нөхцлүүдийг бүрдүүлж өгсөн.

\* Үнэт цаасны тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгад олон улсын нийтлэг жишгийн дагуу үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудыг нэгдсэн бодлого, стандартаар хангах, тэдгээрийн ёс зүйн хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиг үүргийг өөрийгөө зохицуулах байгууллага гүйцэтгэдэг байхаар зохицуулсан нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах ажиллагааг илүү үр дүнтэй болгох боломжтой бүрдүүлж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал ач холбогдолтой юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг үндсэн сууриа болгон ажиллаж, тус хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг гол байгууллагын хувьд Монголын хөрөнгийн биржийн зүгээс хуулийн төслийг боловсруулах ажилд чухал үүрэгтэйгээр оролцсон бөгөөд томоохон хэмжээний бодлогын шинжтэй зөвлөгөө, саналыг өгч ажилласан болно.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үүсч хөгжөөд 22 жилийн түүхийн хуудсыг бичиж байна. Энэ хугацаанд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэн бүрийг хувийн өмчтэй болгох, зах зээлд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах талаар анхаарч ирсэн бөгөөд цаашид улам боловсронгуй болгож хөрөнгө оруулагчид болон зах зээлд оролцогчдод хамгийн ойр байхыг хичээж ажиллах болно.



## “Тулга” ХК болон “Монголэмимпекс” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа

### Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Аргай бест” ХХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг сэргээлээ

Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Аргай бест” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-ны 2012 оны 374 дүгээр тогтоолоор хүчингүй болгосныг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 156 дугаар шийдвэрээр хүчингүй болгосон байна. Үүнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2013 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 33 тоот албан шаардлагаар тус компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг сэргээгээд байна.

СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 143, 144 тоот тогтоолууд, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журм”-ын 58, 59.1-р заалт, “Монголэмимпекс” ХК, “Тулга” ХК нар зохион байгуулалтын хэлбэрээ хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх тухай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн тайлангуудыг тус тус үндэслэн “Тулга” ХК-ийн 131,620 ширхэг, “Монголэмимпекс” ХК-ийн 40,010,457 ширхэг хувьцааг тус тус Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

### Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн хувьцаат компаниуд

2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржид 25 хувьцаат компани нийт 385,348,509 ширхэг хувьцаанд 10,562,078,572 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрээ ирүүлээд байна.

Д/Д	КОМПАНИЙН НЭР	ТООН КОД	ҮСГЭН КОД	САЛБАР	БАЙРШИЛ	НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ /ТӨГ/	НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО ШИРХЭГ	НОГДОЛ АШГИЙН НИЙТ ДҮН /ТӨГ/	ТАРААХ ХЭЛБЭР
1	Говь	354	GOV	В	УБ	125	7,801,125	975,140,625	ХК, ҮЦТТХТ
2	Гермес центр	528	HRM	Е	УБ	5.09	78,543,001	399,783,875	ҮЦТТХТ
3	Шарын гол	309	SHG	А	ДА	50	10,231,389	511,569,450	ҮЦТТХТ
4	АПУ	90	APU	В	УБ	70	74,287,700	5,200,139,000	ҮЦТТХТ
5	Бидисек	522	BDS	Е	УБ	60	11,000,000	660,000,000	ҮЦТТХТ
6	Тахь-ко	44	TAH	В	УБ	56	1,189,983	66,639,048	ҮЦТТХТ
7	Баянтээг	445	BTG	А	ӨХ	100	252,608	25,260,800	ҮЦТТХТ
8	Улаанбаатар БУК	195	BUK	Д	УБ	137	1,128,275	154,573,675	ҮЦТТХТ
9	Тулга	5	TLG	Е	УБ	60	131,620	7,897,200	ҮЦТТХТ
10	Тээвэр дархан	217	TEE	Д	ДА	400	163,349	65,339,600	ҮЦТТХТ
11	Монгол алт	68	ERC	А	ДА	150	265,852	39,877,800	ҮЦТТХТ
12	Ремикон	530	RMC	В	УБ	1.27	78,679,464	100,000,000	ҮЦТТХТ
13	Махимпекс	208	MMX	В	УБ	80	3,800,721	304,057,680	ХК
14	Баянгол ЗБ	13	BNG	Е	УБ	350	423,065	148,072,750	ҮЦТТХТ, ХК
15	Женко тур бюро	521	JTB	Е	УБ	1.6	100,000,000	160,000,000	ҮЦТТХТ, ХК
16	Оллоо	527	OLL	Е	УБ	6	9,700,497	58,202,982	ҮЦТТХТ
17	Атар-Өргөө	17	ATR	В	УБ	500	174,136	87,068,000	ҮЦТТХТ
18	Газар сүлжмэл	34	SUL	В	УБ	4948.2	65,362	323,424,248	ҮЦТТХТ
19	Дорнод худалдаа	311	DES	Е	ДО	500	73,969	36,984,500	ҮЦТТХТ
20	Барилга корпораци	476	BRC	Д	УБ	5000	40,662	203,310,000	ХК
21	Гутал	88	GTL	В	УБ	420	1,618,684	679,847,280	ХК
22	Могойн гол	444	BDL	А	ХӨ	5	829,622	4,148,110	ҮЦТТХТ
23	Ээрмэл	191	EER	В	УБ	52.87	3,479,320	183,951,648	ҮЦТТХТ
24	Материал импекс	379	MIE	Е	УБ	100	1,368,206	136,820,600	ҮЦТТХТ
25	Ган хэрлэн	353	HZB	Е	ДО	300	99,899	29,969,700	ҮЦТТХТ
НИЙТ							<b>385,348,509</b>	<b>10,562,078,572</b>	-

Дэлгэрэнгүй мэдээллийг МХБ-ийн цахим хуудаснаас авна уу. [www.mse.mn](http://www.mse.mn)

\* БАЙРШИЛ: УБ—Улаанбаатар, ДА—Дархан, ӨХ- Өвөрхангай, ДО- Дорнод, ХӨ- Хөвсгөл,

\*САЛБАР: А - Уул уурхай, В - Аж үйлдвэр, С - Хөдөө аж ахуй, Д - Барилга тээвэр, Е - Худалдаа үйлчилгээ





2013 оны 6 сарын 3  
(15, 16-р хэвлэл)

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

## Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас шинэчлэгдлээ

Үнэт цаасны зах зээлийн мэдээ мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай хүргэх, хүртээмжтэй болгох зорилгоор Монголын хөрөнгийн биржийн зүгээс албан ёсны цахим хуудсаа шинэчиллээ.

Шинэчилсэн цахим хуудас 7 үндсэн цэснээс бүрдэж байгаа. Үүнд:

**Бидний тухай** цэснээс Монголын хөрөнгийн биржийн түүхэн замнал, удирдлага, зохион байгуулалт, жилийн тайлан болон амралтын өдрүүдийн хуваарийн талаарх мэдээллийг авах боломжтой.

**Компанийн бүртгэл** хэсэгт үнэт цаас гаргах ач холбогдол, үнэт цаас гаргахад тавигдах шалгуур шаардлага, бүртгэлийн үйл явц, бүртгүүлэхэд төлөх төлбөр хураамж, бүрдүүлэх материал, үнэт цаасны бүртгэлтэй холбоотой дүрэм журмууд, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн жагсаалт, тэдгээрийн танилцуулга, санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, ногдол ашгийн мэдээлэл гэх мэт бүртгэлтэй холбоотой бүхий л мэдээлэл агуулагдаж байна.

Түүнчлэн, бүртгэлтэй хувьцаат компаниуд манай веб сайтад нэвтрэх тус тусын нэр, админ эрхтэй байх бөгөөд компаниуд Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх зааврын дагуу мэдээллээ оруулахаар тохируулсан болно.

Хөрөнгийн зах зээлд ажиллах мэргэжлийн боловсон хүчний эрэлт, хэрэгцээг хангах, сонирхсон иргэд, оюутан, сурагчдад үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох байнгын болон цаг үеийн асуудлаар сургалт, семинари зохион байгуулах зорилгоор 2005 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “Хөрөнгийн зах зээлийн сургалтын төв”-ийг байгуулсан.

Монгол Улсад хөрөнгийн зах зээл шинэ тутам хөгжиж байгаа ч эхнээсээ үр ашгаа өгч эхэлж байна. Үүнийг цааш нь зөв голдрилоор хөгжүүлэхэд юуны өмнө нийт оролцогчдын мэдлэг боловсрол чухал учраас бид зах зээлд оролцогчдод системтэй мэдлэг олгоход анхаарч МХБ-ийн Сургалтын төвөөс хөрөнгийн зах зээлийг сонирхогч иргэдэд зориулан “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох” сургалтыг сар бүр зохион байгуулж өнөөдрийн байдлаар нийт 3,000 гаруй хүнийг хамруулаад байна.

Сургалтын төв нь байнгын үйл ажиллагаа явуулах ба багшлах боловсон

Ингэснээр компанид гарч буй өөрчлөлтүүдийг цаг алдалгүй оруулах, олон нийтэд мэдээлэх боломж бүрдэж байгаа юм.

**Зах зээл** цэснээс та бүхэн хувьцаа, бондын зах зээлийн статистик мэдээлэл, үнэт цаасны арилжааны мэдээг 5 минутын хоцрогдолтойгоор шууд харах, захиалгатай үнэт цаасны мэдээллийг тус тус авах боломжтой юм. Цахим хуудасны баруун доод хэсэгт үнэт цаасны арилжааны өдөр тутмын, долоо хоногийн, сарын, улирлын, жилийн, хураангуй болон дэлгэрэнгүй гээд бүхий л тайлан нийтлэгдэж байгаа тул та хүссэн хугацааныхаа үнэт цаасны арилжааны мэдээг авч болно.

**Гишүүн брокер дилерийн компани** хэсгээс Монголын хөрөнгийн биржид гишүүнээр элсэхэд тавигдах ерөнхий шаардлага, гишүүнээр элсэх явц, төлбөр хураамж, бүрдүүлэх материал, холбогдох дүрэм, журам, гишүүн компаниудын жагсаалт, үйл ажиллагаа аны чиглэл, холбоо барих хаяг, санхүүгийн тайлангийн нэгтгэл зэрэг мэдээллийг үзнэ үү. Гишүүн брокер дилерийн компаниудад зориулсан мэдээлэл оруулах цонх байгаа бөгөөд Гишүүн компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх зааврын дагуу гишүүн компаниуд мэдээллээ оруулах шаардлагатай юм.

**Хууль дүрэм журам** хэсгээс зах зээлд мөрдөгдөж буй хуулиуд, СЗХ болон МХБ-

ийн дүрэм журмуудыг авч болохоос гадна энэ хэсэгт МХБ-ээс авсан арга хэмжээний талаарх мэдээлэл мөн багтаж байна.

**Хөгжлийн төв** цэст үнэт цаасны зах зээлтэй холбоотой хичээл, судалгаа, нийтлэл, компаниудад зориулсан мэдээ мэдээлэл, Монголын хөрөнгийн биржээс зохион байгуулдаг Үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалтын талаарх мэдээлүүд орсоноор олон нийтэд илүү хүртээмжтэй бөгөөд үр өгөөжтэй хэсэг болж чадсан юм.

**Мэдээ, мэдээлэл** хэсэгт зах зээлтэй холбоотой мэдээ мэдээлэл, ярилцлага агуулагдана. Та манай цахим хуудасны аль ч цэс рүү орсон Шинэ мэдээ мэдээлэлтэй үргэлж холбоотой байх болно.

Аливаа цэс бүрийн мэдээллийн доор тухайн газар, албатай холбогдох хаяг, утасны дугаарыг байрлуулсан байгаа тул та бүхэн шаардлагатай мэргэжилтнүүдтэй шууд холбогдох боломжтой боллоо. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар байнга зочилдог таньд баярлалаа!

Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар байнга зочилдог таньд баярлалаа!

## Монголын хөрөнгийн биржийн Сургалтын төв

хүчний хувьд санхүүгийн зах зээлд ажиллаж буй төрийн зохицуулах болон мэргэжлийн байгууллагуудын удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон их, дээд сургуулийн багш нар хичээлийг заадаг.

Бид суралцагчидтайгаа нягт холбоотой ажиллаж, эрэлт хэрэгцээг нь байнга судалж, аль болох бага хугацаанд онол, практикийн өргөн мэдлэг олгохыг зорьдог. Бидний нэг давуу тал нь энэ зах зээлийн гол цэг дээр нь буюу Хөрөнгийн Бирж дээрээ практик дадлага олгодог ороо суралцагчдын сонирхлыг илүү татдаг.

Дэлхий нийтийн жишгээр хүн бүр хөрөнгө оруулагч болж, аль ч улсын хөрөнгийн зах зээлд оролцож ашиг олох боломж нээгдсэн энэ үед манай сургалтын төгсөгчид системтэй мэдлэг олж авснаар дотоод, гадаадын аль ч биржийн арилжаанд оролцох чадвартай болоод хөрөнгийн зах зээлийн тухай үндсэн ойлголтоо аваад төгсдөг. Мэдлэгтэй хөрөнгө оруулагч өөрт учрах эрсдэлээ төдий чинээ бууруулж чадна. Түүнчлэн оролцох гэж байгаа зах

зээлийнхээ онцлогыг мэддэг байх ёстой. Өндөр хөгжсөн орнуудын зах зээлээс манай дотоодын зах зээлийн онцлог, анхаарах зүйлс нь юу байна гэдгийг ч бид сургалтын явцад хэлж өгөхийг хичээдэг болно.

Манай сургалтад хамрагдсан хүмүүс өндөр сэтгэгдэлтэй төгсдөг. Цаашид ч бидэнтэй байнгын холбоотой байж хамтран ажиллах нэг суваг нээгдэж байгаа юм.

Мөн байгууллага хамт олны захиалгаар сургалт зохион байгуулж байна.

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт”-ын хичээлийн жилийн сүүлийн сургалт 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдөр эхэлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.mse.mn](http://www.mse.mn) веб эсвэл 11-313747 утсаар холбогдож авна уу.